



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2026.02.25 № 286
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Р.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийг хүргүүлж байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт 13 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Р.НАНДИНЖАРГАЛ

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	1
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуй нэгж
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.05 № 287
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР
ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Р.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос 42.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 38.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 89.2 хувиар биелүүлж ажилласан байна. Орлогын төлөвлөгөө дутуу биелсэн нь ажил олгогч болон даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3.8 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аж ахуй нэгж, байгууллагаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 52.0 хувиар буюу 1.3 тэрбум төгрөгөөр өсч 3.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнд, нэг жилээс дээш насжилттай 19 харилцагчийн авлага байгаа нь нийт авлагын үлдэгдэлд 18.0 хувийг эзэлж байна.

Шалгагдагч байгууллагаас олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авч, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэх шийдвэр гарсан, мөн зарим аж ахуй нэгж, байгууллагатай авлага барагдуулах гэрээ байгуулсан боловч хуваарийн дагуу шимтгэлийг бүрэн шилжүүлээгүй байна.

Аудитын гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тус нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд "SICOS" системийг ашиглаж байна. Уг системээс аудитын явцад ашиглах ерөнхий мэдээллийг авч ашигласан боловч ажил гүйлгээний тоо хэмжээний хязгаартайгаар ерөнхий журнал системээс хөрвүүлэлт хийгддэг бөгөөд эдгээр мэдээлэлд боловсруулалт хийж, ашиглахад хүндрэлтэй байв.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,982,632,594.85	7,383,956,174.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,502,495,580.65	2,556,743,634.31
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,502,495,580.65	2,556,743,634.31
31210	Төгрөг	4,502,495,580.65	2,556,743,634.31
31213	Арилжааны банк дахь харилцах	4,502,495,580.65	2,556,743,634.31
33	АВЛАГА	3,480,137,014.20	4,827,212,540.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага	351,436,481.02	342,539,965.02
33400	Зээлийн хүүгийн авлага	-	62.09
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	2,544,218,409.29	3,868,465,662.87
33500	Бусад авлага	584,482,123.89	616,206,850.52
33510	Байгууллагаас авах авлага	61,610,537.00	42,044,307.18
33520	Хувь хүмүүсээс авах авлага	522,871,586.89	574,162,543.34
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	7,982,632,594.85	7,383,956,174.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	731,722,955.87	1,210,724,015.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	731,722,955.87	1,210,724,015.04
41300	Өглөг	427,395,410.58	544,777,733.94
41360	Бусад өглөг	427,395,410.58	544,777,733.94
41361	Байгууллагад төлөх өглөг	31,683,208.32	7,402,524.51
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	377,569,293.22	520,444,608.40
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	18,142,909.04	16,930,601.03
41400	Урьдчилж орсон орлого	304,327,545.29	665,946,281.10
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	304,327,545.29	665,946,281.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,250,909,638.98	6,173,232,159.77
51	Засгийн газрын хувь оролцоо	7,250,909,638.98	6,173,232,159.77
51200	Хуримтлагдсан үр дүн	7,250,909,638.98	6,173,232,159.77
51210	Өмнөх үеийн үр дүн	13,922,177,673.22	7,206,883,413.81
51220	Тайлант үеийн үр дүн	(6,671,268,034.24)	(1,033,651,254.04)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	7,982,632,594.85	7,383,956,174.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	91,882,568,954.99	106,091,226,197.59
11	ТАТВАРЫН ОРЛОГО	33,452,396,863.70	38,960,923,435.79
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	33,452,396,863.70	38,960,923,435.79
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,230,284,162.23	31,661,414,143.21
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	27,230,284,162.23	31,661,414,143.21
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	2,874,084,378.19	3,380,717,850.49
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	2,330,177,205.03	2,722,188,088.69
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	1,017,851,118.25	1,196,603,353.40

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,058,549.39	67,130,302,761.80
120	Нийтлэг татварын бус орлого	75,058,549.39	163,900,933.80
1201	Хүүгийн орлого	51,876,755.74	38,514,778.43
120002	Бусад хүүгийн орлого	51,876,755.74	38,514,778.43
120003	Торгуулийн орлого	208,500.00	1,251,000.00
120009	Бусад орлого	22,973,293.65	124,135,155.37
122	Тусламжийн орлого		66,966,401,828.00
1221	Хандив тусламж /дотоод/		66,966,401,828.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж		19,331,878,684.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\		19,331,878,684.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\		47,634,523,144.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,355,113,541.90	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,810,497,041.90	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,810,497,041.90	-
1330	Төсвийн захирагчдаас	42,544,616,500.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,544,616,500.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	98,553,836,989.23	107,124,877,451.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,553,836,989.23	107,124,877,451.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,434,540.00	10,304,380.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,434,540.00	10,304,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,721,900.00	7,062,680.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,712,640.00	3,241,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,546,402,449.23	107,114,573,071.63
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		38,413,166,857.48
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		38,413,166,857.48
213104	НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\		38,413,166,857.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,760,228,750.84	68,701,406,214.15
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	59,760,228,750.84	68,701,406,214.15
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,786,173,698.39	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,786,173,698.39	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(6,671,268,034.24)	(1,033,651,254.04)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(6,671,268,034.24)	(1,033,651,254.04)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	104,898,864,387.30	112,350,371,729.88
11	ТАТВАРЫН ОРЛОГО	46,664,999,470.64	38,017,465,553.35
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	46,664,999,470.64	38,017,465,553.35
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	31,190,191,965.97	30,907,929,320.40
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	31,190,191,965.97	30,907,929,320.40

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	3,267,112,342.33	3,286,071,758.84
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	4,228,458,486.25	2,663,430,538.11
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	1,063,998,571.17	1,160,033,936.00
1121	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	6,915,238,104.92	-
112005	Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	6,915,238,104.92	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,250,316.66	74,332,906,176.53
120	Нийтлэг татварын бус орлого	84,250,316.66	7,357,607,832.53
1201	Хүүгийн орлого	51,958,079.33	38,530,347.24
120002	Бусад хүүгийн орлого	51,958,079.33	38,530,347.24
120009	Бусад орлого	32,292,237.33	7,319,077,485.29
122	Тусламжийн орлого	-	66,975,298,344.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	66,975,298,344.00
12215	Төсөв хоорондын хандив,тусламж	-	19,340,775,200.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	19,340,775,200.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	-	47,634,523,144.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,149,614,600.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,604,998,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,604,998,100.00	-
1330	Төсвийн захирагчдаас	42,544,616,500.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,544,616,500.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,502,776,363.99	114,296,123,676.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,502,776,363.99	114,296,123,676.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,080,464.62	43,175,128.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,434,540.00	10,304,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,721,900.00	7,062,680.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,712,640.00	3,241,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,645,924.62	32,870,748.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,645,924.62	32,870,748.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,428,695,899.37	114,252,948,547.53
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	45,701,473,091.69
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	45,701,473,091.69
213104	НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	45,701,473,091.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,351,216,647.62	68,551,475,455.84
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	59,351,216,647.62	68,551,475,455.84
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,077,479,251.75	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,077,479,251.75	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(603,911,976.69)	(1,945,751,946.34)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(603,911,976.69)	(1,945,751,946.34)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,106,407,557.34	4,502,495,580.65
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,502,495,580.65	2,556,743,634.31

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	15,338,436,182.88	15,338,436,182.88
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,416,258,509.66)	(1,416,258,509.66)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	13,922,177,673.22	13,922,177,673.22
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,671,268,034.24)	(6,671,268,034.24)
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	7,250,909,638.98	7,250,909,638.98
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	7,250,909,638.98	7,250,909,638.98
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(44,026,225.17)	(44,026,225.17)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	7,206,883,413.81	7,206,883,413.81
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,033,651,254.04)	(1,033,651,254.04)
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	6,173,232,159.77	6,173,232,159.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	62,064,119,200.00	57,452,697,394.16	4,611,421,805.84	92.6
11	Татварын орлого	42,723,344,000.00	38,111,922,194.16	4,611,421,805.84	89.2
112	Нийгмийн даатгалын орлого	42,723,344,000.00	38,111,922,194.16	4,611,421,805.84	89.2
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,685,111,100.00	30,978,120,754.44	4,706,990,345.56	86.8
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,118,101,300.00	3,289,500,128.45	(171,398,828.45)	105.5
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,654,081,000.00	2,679,806,667.71	(25,725,667.71)	101.0
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,266,050,600.00	1,164,494,643.56	101,555,956.44	92.0
12	Татварын бус орлого	19,340,775,200.00	19,340,775,200.00	-	100.0
122	Тусламжийн орлого	19,340,775,200.00	19,340,775,200.00	-	100.0
122001	Хандив тусламж /дотоод/	19,340,775,200.00	19,340,775,200.00	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,864,831,600.00	68,561,779,835.84	1,303,051,764.16	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,864,831,600.00	68,561,779,835.84	1,303,051,764.16	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,020,700.00	10,304,380.00	3,716,320.00	73.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,020,700.00	10,304,380.00	3,716,320.00	73.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,096,900.00	7,062,680.00	34,220.00	99.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,023,800.00	3,241,700.00	3,682,100.00	46.8

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,850,810,900.00	68,551,475,455.84	1,306,259,244.16	98.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,850,810,900.00	68,551,475,455.84	1,306,259,244.16	98.1
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,850,810,900.00	68,551,475,455.84	1,306,259,244.16	98.1
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(7,800,712,400.00)	(11,109,082,441.68)	3,308,370,041.68	142.4
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,800,712,400.00	11,109,082,441.68	(3,308,370,041.68)	142.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,502,495,580.65	(4,502,495,580.65)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,556,743,634.31	(2,556,743,634.31)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын сан нь тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зорилгоор ажил олгогчийн цалин хөлсний сан, даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө юм.

Тус сан нь Багануур дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг хуульд заасан хугацаанд тогтоон олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа нэгж юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сан нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоолууд, удирдах дээд шатны байгууллага, нэгжийн шийдвэр, эрхийн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Нийгмийн даатгалын сангийн бүх үйл ажиллагаанд цахим программ хангамж ашигладаг бөгөөд дотоод хяналт үе шат бүрт хийгддэг, санхүүжилтийн хувьд Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар эцсийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Аудитын зөвлөмжийг биелүүлж ажилласан мөн байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт зохих хэмжээнд үр нөлөөтэй гэж үнэлэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сан нь НДЕГ-ын даргын 2024 оны А/243 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 598,676.4 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,502,495.6	2,556,743.7	(1,945,751.9)
Авлага	3,480,137.0	4,827,212.5	1,347,075.5
Нийт хөрөнгө	7,982,632.6	7,383,956.2	(598,676.4)
Богино хугацаат өр төлбөр	731,723.0	1,210,724.00	479,001.0
Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	7,250,909.6	6,173,232.20	(1,077,677.4)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,982,632.6	7,383,956.2	(598,676.4)

Мөнгөн хөрөнгө 1,945,751.9 мянган төгрөгөөр буурсан нь НДЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын хэрэгжилттэй холбоотойгоор арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдлийг НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой;

Авлагын үлдэгдэл 1,347,075.5 мянган төгрөгөөр өссөн нь ААН, байгууллагаас авах НДШ-ийн авлага 1,347,247.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Үүнд, Багануур дүүргийн эрүүл мэндийн төвөөс авах авлагын үлдэгдэл 1,149,171.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлан нөлөөлж байна.

Богино хугацаат өр төлбөр 479,001.0 мянган төгрөгөөр өссөн ба энэ нь урьдчилж төлсөн орлого, хувь хүнд өгөх тэтгэмжийн өглөгийн өсөлтөөс шалтгаалсан байна. Үүнд, ААН, байгууллагаас илүү шилжүүлсэн шимтгэлийн орлого 130,063.8 мянган төгрөг, малчин, туслах малчины төрөөс хариуцах шимтгэлийн урьдчилж төлсөн орлого 141,208.3 мянган төгрөг мөн ажилгүйдлийн тэтгэмжийн өглөгийн 213,265.1 мянган төгрөгийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн нь 1,077,677.4 мянган төгрөгөөр буурсан ба үүнд тайлант оны үр дүн гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд НДШ болон бусад орлогоос нийт 115,052,444.1 мянган төгрөгийг бүрдүүлэхээр, тэтгэвэр, тэтгэмж болон бусад зардалд 231,707,868.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд тусгасан орлогын саналыг 72,329,100.1 мянган төгрөгөөр, зарлагыг 161,843,037.3 мянган төгрөгөөр бууруулж, орлогыг 42,723,344.0 мянган төгрөгөөр, зарлагыг 69,864,831.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийт 42,723,344.0 мянган төгрөгийн 10 төрлийн орлогыг бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 38,111,922.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 4,611,421.8 мянган төгрөгөөр дутуу буюу 89.2 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвөөс хариуцан төлөх 3 төрлийн шимтгэлийн орлого 100 хувийн, ААН, байгууллага, даатгуулагчаас төлөх 6 төрлийн орлого 54.5-92.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол 1 төрлийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл огт хангагдаагүй байна. Үүнд,

- ✓ Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлийн орлогоос 44,549.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс уг орлогыг бүрэн төвлөрүүлсэн,
- ✓ Малчин, туслах малчны улсын төсвөөс төлөх шимтгэлийн орлогоос 192,456.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр улсын төсвөөс бүрэн авч, орлогыг 100 хувь биелүүлсэн,
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхийн төрөөс хариуцах шимтгэлийн орлогоос 96,306.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр тус орлогыг улсын төсвөөс бүрэн төвлөрүүлсэн,
- ✓ ААН, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэлийн орлогоос 22,101,611.2 мянган төгрөгийг санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 20,414,157.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 92.4 хувиар биелүүлсэн,

- ✓ Даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогоос 18,260,107.8 мянган төгрөгийг бүрдүүлэх төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 16,107,666.2 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 88.2 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн,
- ✓ Бусад орлогоос 109,669.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн ба 83,696.2 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөө 76.3 хувьтай биелсэн,
- ✓ Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогоос 1,527,254.1 мянган төгрөгийг санд төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,072,186.7 мянган төгрөгийг бүрдүүлэн, орлогын төлөвлөгөөг 70.2 хувиар биелүүлсэн,
- ✓ Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлийн орлогоос 44,549.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 36,130.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөө 66.9 хувийн гүйцэтгэлтэй байна,
- ✓ ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогоос 118,752.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн ба орлогын төлөвлөгөөг 54.5 хувиар биелүүлж, 64,773.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн,
- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Малчны тухай хуульд малчны тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх заалтыг тусгасан боловч нарийвчилсан журам, зохицуулалт батлагдаагүй шалтгаанаар тайлант онд малчдын нөхөн төлөх шимтгэлийн орлого болох 218,592.2 мянган төгрөгийг бүрдүүлээгүй байна.

Тэтгэвэр, тэтгэмж болон бусад зардлыг санхүүжүүлэхэд 69,864,831.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 68,561,779.8 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1,303,051.8 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан. Үүнд, тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 1,299,335.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 3,716.3 мянган төгрөгөөр хэмнэжээ.

Хүснэгт 2. Зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/					
д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл, хувиар
1	Нийт зарлага	69,864,831.6	68,561,779.8	1,303,051.8	98.1%
1.1	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,850,810.9	68,551,475.5	1,299,335.5	98.1%
1.2	Бусад зардал /олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ, банкны шимтгэл/	14,020.7	10,304.4	3,716.3	73.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тэтгэвэр, тэтгэмжийн дүнг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах, харилцагч байгууллага, аж ахуй нэгжээс авах НДШ-ийн авлагын он дамжсан үлдэгдлийг жилийн эцэст баталагаажуулж, баримтжуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр гүйцэтгэж, компанийн захирал М.Буянбулган анхан шатны чанарын хяналтыг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүүгийн аудитын албаны аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багануур дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Баталгаат тооцоолол Аудит” ХХК-д 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд ” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 98,553,837.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 985,538.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэрэг батлагдсан төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 118,469,123.2 мянган төгрөгийн 1,334 гүйлгээ, зарлагын 115,780,938.5 мянган төгрөгийн 857 гүйлгээ гарсан ба эдгээр мэдээллийг бүрэн, цаг хугацаандаа байршуулсан байна. Мөн санхүүгийн тайлан, мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь бүрэн байршуулж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус сангийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, илрүүлсэн алдаа, зөрчлийн дүнг жилийн эцсийн аудитын дүн, дүгнэлтэд нэгтгэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн санхүүгийн программын хөгжүүлэлт бүрэн дуусаагүй, санхүүгийн тоон мэдээллийг иж бүрэн, үнэн зөв гаргах, мөнгөн гүйлгээний журналын холбоос дутуу зэргээс шалтгаалан ажил гүйлгээний эх олонлогийг бүрэн ирүүлэхэд хүндрэлтэй байсан.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 122,778.7 мянган төгрөгийн зөрчил^[1] илэрч, 2 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн 122,778.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй тул “зөрчилгүй” дүгнэлт өглөө

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын үлдэгдлийн баталгаажуулалт, баримтжуулалтай холбоотой асуудал

***Илрүүлэлт-1:** Аж ахуй нэгж байгууллагаас авах НДШ-ийн авлагын 69,838.5 мянган төгрөгийн үлдэгдлийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2025 оны 12 дугаар сарын тайлан /НД7 маягт/, эсхүл 2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар үйлдсэн тооцоо нийлсэн актаар баримтжуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ. 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан,*

баталгаажуулах,” гэж заасантай тус тус нийцээгүй, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгж байгууллагаас авах НДШ-ийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланг тасалбар болгох өдрөөр харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулж, баримтжуулж байх.

2. Авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Санхүүгийн тайланд тэтгэвэрийн даатгалын сангийн байгууллагаас авах бусад авлага дансанд 9,884.7 мянган төгрөгийн, тэтгэмжийн даатгалын сангийн байгууллагаас авах бусад авлага дансанд 27,422.8 мянган төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, мөн байгууллагад төлөх өглөг дансанд 15,632.8 мянган төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөг бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”. 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай тус тус нийцээгүй, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөж байх. Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өглөгийг тодорхой болгож, авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлан бэлтгэх өдрийн байдлаар баримтжуулаагүй.	1	69,838.5					1	69,838.5
Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өглөг бүртгэлтэй байна	1	52,940.2					1	52,940.2
Дүн	2	122,778.7					2	122,778.7

¹¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.